



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2023/44/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК

Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: omnogovi@audit.gov.mn

2022.02.09 № 28

танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Х.ОТГОНМӨНХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын данс бүртгэлд тусгагдсан 130.0 сая төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгсэл, 61.2 сая төгрөгийн 16 мотоциклийг бусад байгууллагуудад гэрээгээр эзэмшүүлж байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын нэмэлт санхүүжилтээр 62.3 сая төгрөгийн судалгааны ажил хүлээн авч бүртгэсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөө үзүүлжээ.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020026

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)		
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	408.1	629.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	43,358.0	43,945.5
Нийт хөрөнгийн дүн	43,766.1	44,574.7
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	43,766.1	44,574.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	43,766.1	44,574.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	888.4	1,916.1
Үйл ажиллагааны зардлын дүн	661.4	1,107.5
Үйл ажиллагааны үр дүн	227.0	808.6
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	227.0	808.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,539.1	43,766.1
Тайлант оны үр дүн	227.0	808.6
Эцсийн үлдэгдэл	43,766.1	44,574.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	699.9	1,195.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	695.7	1,162.8
Үйл ажиллагааны ЦМГ	4.1	33.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(4.1)	(33.0)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	516.5	467.6
Урсгал зардал	516.5	467.6
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	516.5	467.6
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	516.5	516.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 59.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 59.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

5.2.1 Худалдан авалттай холбоотой асуудал.

Илрүүлэлт: 2022 онд аймгийн Засаг даргын захирамжаар “тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 59.4 сая төгрөгийн модны үрсэлгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон босго үнэд багтаан 3 аж ахуйн нэгжид хуваан шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийн хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу цахим тендер зарлан шалгаруулж ажиллах

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга хийгдээгүй												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Босго үнээс давсан ажилд	1	59,400.0			1	59,400.0						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

холбогдох хууль зөрчин шууд гэрээ байгуулсан												
Дүн	1	59,400.0			1	59,400.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			